



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 032

Ховд


Б.Лхагвабаярын цалинг шинэчлэн
тогтоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн арга зүйч Борхүүгийн Лхагвабаярын үндсэн цалинг шинэчлэн тогтоосугай.

2. Б.Лхагвабаярын үндсэн цалинг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын доод хэмжээ”-ний ТҮ-6 дахь зэрэглэл буюу 1,003,000 (нэг сая гурван мянга) төгрөгөөр жишин тогтоож, холбогдох нэмэгдлийг олгохыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Б.Нямдэлгэр)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.САНДАГСҮРЭН